



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/169

Булган сум

**Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс
тогтоох ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоол, Булган аймгийн ИТХ-ын 2022 оны XIV Нуралдааны XIV/01 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн нутаг дэвсгэрт усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох ажлыг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 01-ийг хүртэл хугацаанд зохион байгуулахыг Хануй голын сав газрын захиргаа (Д.Бямбажаргал), Сэлэнгэ голын сав газрын захиргаа (М.Чулуунзагд), Туул голын сав газрын захиргаа (Д.Нямдорж), Орхон-Чулуут голын сав газрын захиргаа (Ч.Отгонбаатар), Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа (Д.Эрдэнэболд) нарт үүрэг болгосугай.

2. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох ажлын зардлыг хавсралтаар баталсугай.

3. Хамгаалалтын бүс тогтоох ажилд шаардагдах 74 915 500 (Далан дөрвөн сая есөн зуун арван таван мянга таван зуу) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын Усны сан бүхий хамгаалалтын бүс тогтоох ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

4. Хануй, Сэлэнгэ, Туул, Орхон-Чулуут, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаануудтай усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох ажлын гэрээ байгуулж, гүйцэтгэлд, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр), сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хамтарч ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Засаг Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010120

Аймгийн Засаг даргын 2023 оны
03. дугаар сарын 20-ны өдрийн А/169 дугаар
захирамжийн хавсралт



Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох зардлын хуваарилалт

Д/д	Сав газрын захиргааны нэр	Хамгаалалтын бүс тогтоох зардал (төгрөг)
1	2	3
1	Хануй голын СГЗ	12945200
2	Сэлэнгэ голын СГЗ	19779800
3	Туул голын СГЗ	12346900
4	Орхон-Чулуут голын СГЗ	16479400
5	Хөвсгөл нуур-Эгийн голын СГЗ	13364200
	Нийт	74915500